



ЭРДЭНЭ СУМЫН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

2013 оны Санхүүгийн Тайлан

ҮАГ-ын харьяа Төв аймгийн Аудитын газар нь Төрийн Аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, холбогдох хууль, журам зааварт нийцүүлэн аудит хийж байна.

Лавлах зүйл байвал 70272248 дугаарын утаснаас лавлана уу?

Л.Жаргалсайхан
Аймгийн Тэргүүлэх аудитор
өрөөний утас 70272582

Ц.Саранчимэг - Аудитор
өрөөний утас 70273465

Аймгийн Аудитын газар
Төрийн байгууллагын ордон

Аудитыг дуусгавар болгосон тухай тайлан

АГУУЛГА

ХУУДАС

• Аудит хийж дууссан тухай мэдэгдэл	2-3
• Танилцуулга	4
• Санхүүгийн дотоод хяналт	4-8
• Гол шийдлүүд	9
• Тайлбар мэдүүлгийн захидал.....	9
• Аудитын санал дүгнэлт	9

**Төв аймгийн Эрдэнэ сумын төсвийн байгууллагууд,
тусгай сангууд 2013 оны Санхүүгийн Тайланд
аудит хийж дууссан тухай мэдэгдэл**

Бид Эрдэнэ сумын төсөвт байгууллагууд болон тусгай сангуудын 2013 оны Санхүүгийн тайланд аудитаа хийж дуусч байгаа ба Сумын Засаг дарга болон төсвийн шууд захирагч болон Ерөнхий менежерт энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаархи бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Эрдэнэ сумын Засаг дарга нь тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Удирлагын зөвлөлийн анхаарлыг дараах зүйлд чиглүүлж байна:

**Гол санхүүгийн хяналтууд
хамрагдсаныг тодруулбал:**

- Орлого санхүүжилт, бараа ажил үйлчилгээний урсгал зардал, цалингийн зардал, бараа материал, үндсэн хөрөнгө авлага, мөнгөн хөрөнгө, өглөг бусад асуудлуудыг хамруулсан бөгөөд байж болзошгүй эрсдлийг тооцож холбогдох батламж мэдэгдлүүд хэрхэн хангагдаж байгааг нотлох үүднээс холбогдох стандарт, журам зааврын дагуу шаардлагатай горимыг хэрэгжүүлсэн.

**Гол илрүүлсэн зүйлс буюу аудитын үр
дүнгээс гарсныг тодруулбал:**

- ✓ Эрдэнэ сум нь 2013 онд орон нутгийн орлого 52826.3 мянган төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 117762.2 мянган төгрөг төвлөрч батлагдсан төлөвлөгөөнөөс 64935.4 мянган төгрөг буюу 222.9 хувиар давж биелсэн.
- ✓ Орон нутгийн хөгжлийн сангаас хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын ажлуудын гүйцэтгэлийг санхүүгийн тайланд бүрэн тусгаагүй байна. Үүнд малын үүлдэр угсааг сайжруулахаар Сэлэнгэ аймгийн Хушаат сумын цөм сүрэг, Сэлэнгэ үүлдрийн 1 хязаалан, 4 шүдлэн, 14 бухан бяруу нийт 19 хээлтүүлэгч малыг орлого авч бүртгээгүй байна.

*ЕМ, Санхүүгийн албанаас
ҮАГазрын харьяа Төв аймгийн Аудитын
Газар тайлбар мэдүүлэг хүлээж байгаа
илэрсэн алдааг хэрхэн залруулсан талаар
тайлбар ирүүлнэ үү*

Аудитыг дуусгаж аудитын явцад олж авсан ажлын баримтанд үндэслэн, дээрх зөрчлүүд материаллагын урьдчилан тогтоосон түвшингээс бага тул Зөрчилгүй санал дүгнэлт гаргахаар Тэргүүлэх аудиторт санал оруулсан байгаа

- ҮАГазрын харьяа Төв аймгийн Аудитын Газрын дарга, Тэргүүлэх Аудитор 2014.03.25-ны өдөр санал дүгнэлтэнд гарын үсэг зурна.

Эцэст нь аудитын явцад нягтлан бодогч, нярав болон бусад албан тушаалтан бидэнтэй хамтран ажиллаж бидний ажилд дэмжлэг болж байсанд гүнээ талархаж байна.

**ҮАГ-ЫН ХАРЬЯА ТӨВ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР**

Танилцуулга

Эрдэнэ сумын 2013 оны 12 дугаар сарын 31-ээр тасалбар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланд аудитаа хийж дуусч байгаа ба сумын Засаг даргад энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд сумын Засаг дарга нь тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Бидний 2013 оны тайланд хийсэн аудит нь 2 гол элементтэй:

- Санхүүгийн хяналтын системийг дахин шалгах;
- Жилийн санхүүгийн тайланд аудит хийх;

Аудитаас үүдэн гарсан асуудлууд дараах хэсэгт хураангуйлагдсан.

Санхүүгийн дотоод хяналтыг дахин шалгах

Аймгийн Аудитын газар санхүүгийн хяналтыг дахин шалгаж үзээд санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг баталгаажуулах шаардлагатайг авч үзсэн. Бидний дахин шалгалт нь Эрдэнэ сумын төсөвт байгууллагууд, тусгай сангуудын хяналтыг аймгийн Аудитын газрын санхүүгийн эрсдэл ба хяналтын мэдээтэй харьцуулан шинжлэн үзсэн. Үүний үр дүнд цаг ямагт үр өгөөжтэй материаллаг алдаанаас сэргийлж чадах гол санхүүгийн хяналтыг онцгойлон үзсэн юм.

Бид Эрдэнэ сумын Засаг дарга тухайн жилийн эдгээр хяналтын асуудлын тухай тайлагнасан.

Дараахь түвшний хяналтын асуудал бидний дахин шалгалтын үр дүнгээс гарсан бөгөөд үүнд Эрдэнэ сумын төсөвт байгууллагууд, тусгай сангуудын удирдлагын анхаарлыг хандуулж байна.

Орлого санхүүжилтийн талаар:

Эрдэнэ сум нь 2013 онд орон нутгийн орлого 52826.3 мянган төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 117762.2 мянган төгрөг төвлөрч батлагдсан төлөвлөгөөнөөс 64935.4 мянган төгрөг буюу 222.9 хувиар давж биелсэн.

Мөн аймгийн төсөвт төвлөрүүлэх орлого батлагдсан төлөвлөгөөгөөр 414596.0 мянган төгрөг, гүйцэтгэлээр 430508.0 мянган төгрөг буюу биелэлт 103.8 хувьтай, улсын төсөвт төвлөрүүлэх орлого төлөвлөгөөгөөр 29200.0 мянган төгрөг, гүйцэтгэлээр 55929.7 мянган төгрөг биелэлт 191.5 хувиар тус тус биелэсэн байна.

Сумын орон нутгийн орлогын данс оны эхэнд 12275.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан. Орон нутгийн орлогын дансанд 117762,2 мянган төгрөгийн татварын орлого, илүү авсан санхүүжилт буцаасан 5330,0 мянган төгрөг нийт 123092,2 мянган төгрөгийн орлого орж, орлогын данснаас санхүүжилтэнд НЕҮйлчилгээнд 99669,1 мянган төгрөг, байгаль хамгаалах санд 2689,9 мянган төгрөг, татвар орлого буруу орсныг буцаасан 150,9 мянган төгрөг, орон нутгийн ерөнхий орлогын дансанд 27528,0 мянган төгрөгийн төвлөрүүлж оны эцэст үлдэгдэлгүй тайлагнагдсан байна.

2013 онд НЕҮйлчилгээний санхүүжилтийг ЗДТГазарт 241170,6 мянган төгрөг, ИТХ-51063,1 мянган төгрөг, Баг 56288,1 мянган төгрөг нийт төсөв 348521,8 мянган төгрөг зарцуулахаар батлагдсанаас гүйцэтгэлээр орон нутгийн орлогоос 99669,1 мянган төгрөг, аймгаас санхүүжилт 254042,3 мянган төгрөг нийт 353711,4 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна. Үүнээс

ЗДТГазарт 246361,9 мянган төгрөг, ИТХуралд 51061,3 мянган төгрөг, Багт 56288,1 мянган төгрөгийн санхүүжилт тус тус авсан байна.

Тусгай зориулалттай шилжүүлгээр ЕБСургуульд 554520,1 мянган төгрөг, Цэцэрлэгт 233242,4 мянган төгрөг, Эмнэлэгт 210023,1 мянган төгрөг, Соёлын төвд 49822,5 мянган төгрөг нийт 1047608,1 мянган төгрөгийн эх үүсвэрийг нэгтгэсэн байна. Дээрх байгууллагуудын жилийн эцсийн зарцуулаагүй төсвийн үлдэгдэл 9102,0 мянган төгрөгийг, НЕҮйлчилгээний байгууллагуудын оны эхний харилцах дансны үлдэгдэл 12916,1 мянган төгрөгийг болон оны эцсийн зарцуулаагүй үлдэгдэл 8348,8 мянган төгрөгийг тус тус татан төвлөрүүлсэн байна

Халамжийн сангийн санхүүжилт 267556,6 мянган төгрөг төгрөгийг халамж үйлчилгээний санд төвлөрүүлснээс халамжийн тэтгэвэрт 208291,8 мянган төгрөг, жирэмсэн амаржсан эхийн тэтгэмжинд 43769,9 мянган төгрөг, хоол тэжээлийн тусламж дэмжлэгт 13810,0 мянган төгрөг, олон нийтийн оролцоонд түшиглэсэн зардалд 1685,0 мянган төгрөг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн дансны санхүүжилтээр ЗДТГазарт 24555,1 мянган төгрөг, Сургууль 3693,8 мянган төгрөг, ЭМТөв 450,0 мянган төгрөг, Цэцэрлэг 2000.0, Соёлын төв 4683,3 мянган төгрөг нийт 35382,2 мянган төгрөгийн орлого, 35305,5 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж оны эцэст 76,7 мянган төгрөгийн үлдэгдэлийг мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд нэгтгэсэн.

Мөнгөн хөрөнгийн талаар:

Сумын нэгдсэн тайлангаар оны эхэнд ЗДТГазар 5900.8 мянган төгрөг, ИТХурал 1774.0 мянган төгрөг, Баг 5241.4 мянган төгрөг нийт 12916.2 мянган төгрөг, Тусгай зориулалтийн сангууд 82577.6 мянган төгрөг, Орон нутгийн орлогын данс 12275.8 мянган төгрөг, эм эргэлтийн сан 2280.9 мянган төгрөг, нийт 110050.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан.

Жилийн эцсийн байдлаар Тусгай зориулалтийн сангууд 28712.8 мянган төгрөг, Орон нутгийн орлогын данс 27528.0 мянган төгрөг, эм эргэлтийн сан 4133.1 мянган төгрөг, Нэмэлт төсвийн санхүүжилтийн дансны үлдэгдэл 76.7 мянган төгрөг нийт 60450,7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй нэгтгэгдсэн байна. Энэ Төрийн сангийн төлөөлөгчийн ирүүлсэн үлдэгдлийн баталгаагаатай болон ХААН банкнаас ирүүлсэн эм эргэлтийн сангийн үлдэгдлийн баталгаагаатай тохирч байна.

Авлага, өглөгийн талаар:

Сумын нэгдсэн тайлангаар Оны эхэнд 100549,4 мянган төгрөгийн авлага, оны эцэст 362695,2 мянган төгрөгийн авлагатай нэгтгэгдсэн ба оны эхнээс авлага 262144,7 мянган төгрөгөөр өссөн ба жилийн эцсийн нийт авлагын 130771,8 мянган төгрөгийн ОНХСангийн дутуу хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлын авлага болон 229592,6 мянган төгрөгийн СХСангийн зээлийн авлага нь 360364,4 мянган төгрөгийн буюу 99,3 хувийг эзэлж байна. Өглөг оны эхэнд 10727,7 мянган төгрөг, оны эцэст 1811,3 мянган төгрөгийн өглөгтэй нэгтгэгдсэн байна. Өглөг 8916,4 мянган төгрөгөөр буурсан байна.

Бараа материал

Сумын нэгдсэн тайлангаар Бараа материалын данс нь оны эхэнд 101663,7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 370155.8 мянган төгрөгийн бараа материал нэмэгдэж, 357953.2 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж, жилийн эцэст 113866.4 мянган төгрөгийн үлдэгдэл нэгтгэгдсэн байна. Оны эхнээс 12553,2 мянган төгрөгөөр бараа материал өссөн байна. Малын тэжээл 8427,3 мянган төгрөг, Хүнс 4510.9 мянган төгрөг, Шатах тослох материал 1907.4 мянган төгрөг

Үндсэн хөрөнгө

Сумын нэгдсэн тайлангаар Үндсэн хөрөнгийн данс нь оны эхэнд 3027506,3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 170278,2 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, 32376,5 мянган төгрөгийн хөрөнгө хасагдаж, жилийн эцэст 3165408,0 мянган төгрөгийн үлдэгдэл нэгтгэгдсэн байна. Тайлант онд байгуулсан үндсэн хөрөнгийн элэгдэл 30738,9 мянган төгрөг үлдэх өртөг 1949274,3 мянган төгрөг байна.

Тусгай зориулалтын сангууд

Сумын хэмжээнд 6 сан үйл ажиллагаа явуулж байгаа ба эм эргэлтийн сангаас бусад сан Төрийн сангийн харилцах дансаар гүйлгээ хийгдэж хянагддаг байна. Сангуудыг тодруулахад:

Байгаль хамгаалах сангийн талаар:

Байгаль хамгаалах сан 1244,3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлант хугацаанд аймгийн санхүүгийн дэмжлэгээр 12000,0 мянган төгрөг, орон нутгийн орлогоос 2689,9 мянган төгрөгийн санхүүжилт, бусад орлого 6199,9 мянган төгрөг нийт 20889,8 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдэж шатахуунд 6723,9 мянган төгрөг, хогны машины сэлбэгэнд 1582,0 мянган төгрөг, хогны поошиг 700,0 мянган төгрөг, Пост барих зардал 8500,0 мянган төгрөг, үнэт цаас 170,0 мянган төгрөг, хог түрсний хөлс 180,0 мянган төгрөг, тэмцээн 504,0 мянган төгрөг ЭМТөвд 450,0 мянган төгрөг нийт 18810,0 мянган төгрөг зарцуулж 3324,1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн талаар:

Орон нутгийн хөгжлийн сан тайлант онд 184441,8 мянган төгрөгийн санхүүжилт орж, 164441,8 мянган төгрөгийг зарцуулж 20000,0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Сумын ИТХурлын 2013.05.03-ны өдрийн 19 тоот тогтоолоор эрэмбэлсэн жагсаалтыг хэлэлцээд 251100,0 мянган төгрөгийг Сүү хөргөлтийн цех, малын үүлдэр угсааг сайжруулах, эрчим хүчний трансформатор суурилуулах, нийтийн эзэмшлийн тохижилтыг сайжруулах, цэвэр усны үйлдвэр байгуулах зэрэг хөрөнгө оруулалтын ажилд зарцуулахаар шийдвэрлэсэн байна. Гүйцэтгэлээр тогтоол заагдсан ажлуудыг ирсэн санхүүжилтийн хүрээнд 164441,8 мянган төгрөгийг зарцуулж хэрэгжилт 72,7 хувийн биелэлттэй байна. Орон нутгийн хөгжлийн сангаас малын үүлдэр угсааг сайжруулахаар Сэлэнгэ аймгийн Хушаат сумын цөм сүрэг, Сэлэнгэ үүлдрийн 1 хязаалан, 4 шүдлэн, 14 бухан бяруу нийт 19 хээлтүүлэгч авчирч багуудад тараан байршуулсныг санхүүгийн тайланд бүртгэлд аваагүй байна. Дутуу хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлын үлдэгдэлийг санхүүгийн тайланд 130771,8 мянган төгрөгийн авлагаар тусгасан байна.

Мал хамгаалах сангийн талаар:

Мал хамгаалах сан оны эхэнд 5917,8 мянган төгрөг, өвс борлуулсан орлого 4025,0 мянган төгрөг, актын барагдуулалт 210,0 мянган төгрөг, нийт 4235,0 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж, өвс тэжээлийн үнэ 7000,0 мянган төгрөг, түүний тээврийн зардалд 2650,0 мянган төгрөг зарцуулж оны эцэст 502,8 мянган төгрөгийн харилцах дансандаа үлдэгдэлтэй байна. Бараа материалын дансанд 3000,0 мянган төгрөгийн өвс тэжээлийн үлдэгдэлтэй байна. Үүнийг тооллогын комисс тоолж үлдэгдэлийг баталгаажуулсан баримт байхгүй байна.

Сум хөгжүүлэх сангийн талаар:

Сум хөгжүүлэх сан оны эхэнд 74916,8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлант онд ХЭДСангаас санхүүжилт 60000,0 мянган төгрөг, нэр данс зөрүүтэй орлого 33645,1 мянган төгрөг, зээл ,

зээлийн хүүгийн төлөлт 102521,3 мянган төгрөг, ММСангийн худгийн орлого 2038,9 мянган төгрөг, актын төлбөр 1812,8 мянган төгрөг, илүү авсан мөнгийг тушаасан 2000,0 мянган төгрөг/ нутгийн иргэдийн уулзалт/ нийт 202018,2 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж, 228500,0 мянган төгрөгийн зээл олгож, шатахуунд 987,5 мянган төгрөг актын төлбөрт 645,1 мянган төгрөг, гэрийн мод бэлтгэхэд 2750,0 мянган төгрөг, ЕБСургуульд илүү шилжүүлсэн төмсний мөнгө 460,0 мянган төгрөгийг олгосон, 5000,0 мянган төгрөгийг нутгийн иргэдийн уулзалтанд зарцуулсан, үйл ажиллагааны зардал бичгийн зардалд 381,0 мянган төгрөг, нэр данс зөрүүтэй буцсан гүйлгээ 272368,7 мянган төгрөг нийт 272368,7 мянган төгрөгийг зарцуулж оны эцэст 4566,2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. СХСангийн хөрөнгийг захиран зарцуулахдаа сангийн журмыг мөрдөж ажиллаагүйгээс нутгийн иргэдийн уулзалтанд 3000,0 мянган төгрөг, гэрийн мод бэлтгэсэн 2750,0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна. СХСан 2013 оны эхэнд 95447,0 мянган төгрөгийн авлага, тайланд онд 228500,0 мянган төгрөгийн зээл олгож, 102521,3 мянган төгрөгийн зээл хүүгийн төлөлт хийгдэж 229592,5 мянган төгрөгийн зээлийн авлагатай байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сан:

ГХУССан оны эхэнд 498,7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй аймгийн санхүүгийн дэмжлэгээр 1100,0 мянган төгрөг, сумын ИТХурлын санхүүжилтээр 2838,0 мянган төгрөг, кассекний үнэ 300,0 мянган төгрөг, тамхины зөвшөөрөл 250,0 мянган төгрөг нийт 4489,0 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж, тэмцээний шагналд 2267,5 мянган төгрөг, шатахуун 434,5 мянган төгрөг, томилолт 116,0 мянган төгрөг, 10 жилийн ойн арга хэмжээнд 1000,0 мянган төгрөг, кассек авахад 750,0 мянган төгрөг, урамшуулалд 100,0 мянган төгрөг нийт 4668,0 мянган төгрөгийг зарцуулж оны эцэст 319,7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Эргэлтийн эмийн сан:

Эргэлтийн эмийн сангийн үйл ажиллагаа 2143,2 мянган төгрөгийн ашигтай ажилласан ч ЭМТөвийн үйл ажиллагаатай холбоотой болон бүртгэл санхүүгийн программ хангамж 1559,1 мянган төгрөгийн зарлага гарч тайлант үеийн цэвэр ашиг 584,1 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна. Өмнөх оноосоо авлага буурсан хэдий ч эргэлтийн хөрөнгийн 15 хувийг эзэлж байна. Дансны авлага багийн эмч нартай холбоотой 374,2 мянган төгрөг, эд хариуцагч Цэрэнхандтай холбоотой 528,6 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. Иймд авлагыг 2014 оны 2-р улиралд багтаан барагдуулахгүй бол акт болгож шийдвэрлэхийг анхааруулж байна. Дансны өглөг 558,2 мянган төгрөгийн өглөгийн тооцоо нийлсэн актгүй байна. Үүнд Еврофарм 340,4 мянган төгрөг, Төв эм хангамж 91,5 мянган төгрөг оны эхний үлдэгдэл 97,3 мянган төгрөг, Цомбо ХХК 28,9 мянган төгрөг өглөгүүдийн тооцоо нийлсэн актгүй байна

Бидний дахин шалгалтын үр дүнд дээр дурдсан хэсгүүдийн дотоод хяналтын систем нь тухайн жилд хангалттай байсан ба нягтлан бодох бүртгэл нь Санхүүгийн тайлангийн зохистой үндэс болсон нь ажиглагдсан юм. Сайжруулах шаардлагатай байж болох хэд хэдэн санхүүгийн хяналтын талаар хавсралт бүхий удирдлагын захидалд тусгасан болно.

Аудитын явцад хийгдсэн гол шийдлүүд

Дараах хэсэгт Санхүүгийн тайлангийн аудит явцад гарсан гол асуудлуудыг хураангуйлан тэмдэглэсэн.

- Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийг мөрдөж ажиллах

- Санхүүгийн тайлан гаргалт уялдаа холбоог сайжруулах
- МУ-ын ЗГазрын 2012.11.09 –ний өдрийн 311-р тогтоолыг хэрэгжүүлэн байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтын үр өгөөжийг дээшлүүлэх.

Бидний илрүүлсэн зүйлс болон дээрх санхүүгийн дотоод хяналтын талаар санал нь удирдлагын захидалд тусгагдсан байна. Санхүүгийн гүйлгээнүүд нь хүлээн зөвшөөрхүйц зохицуулагдсаныг тэмдэглэсэн.

Залруулагдаагүй алдаа

1. Аудитын стандарт нь Аймгийн Аудитын газарт аудитын явцад илэрсэн тодорхой биш болон залруулагдаагүй алдаанд анхаарал тавихыг шаарддаг. Аудитаар илрүүлсэн алдаануудыг төсөвт байгууллагуудад залруулсан ба нэгтгэлд залруулагдаагүй алдаа байхгүй болно.

Тайлбар мэдүүлгийн захидал

2. Аудитын үйл явцад Аймгийн Аудитын газар хөндлөнгийн аудиторын хувьд удирдлагын зүгээс гаргасан баталгаанд тулгуурлах ёстой байсан ч хараат бус байдлын хувьд энэ батламжийг дагах нь зохистой байсангүй. Аудитын гүйцэтгэл бүрд /тайлбар мэдүүлгийн захидлаар/ санхүү бүртгэлийн даргаас эдгээр батлагааг бичгээр баталгаажуулан олж авахыг хүсч байна.

Аудитын санал дүгнэлт

3. Аймгийн Аудитын газраас танай байгууллагын 2013 оны 12 дугаар сарын 31 –нээр тасалбар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайланд **зөрчилгүй** санал дүгнэлт гаргахаар санал оруулж байна.

Аймгийн Аудитын газар

2014.03.25